



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 284

Улаанбаатар хот

“Хаан банк” ХХК-д кастодианы үйл ажиллагаа т
эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 63 дугаар зүйлийн 63.1.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 85/A-106 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хаан банк” ХХК-д үнэт цаасны зах зээлд кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд биелүүлж ажиллахыг “Хаан банк” ХХК /Норихико Като/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



3.НАРАНТУЯА

000876